



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А481

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн цэвэрлэх байгууламж (Сэлэнгэ сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Хулдын бүлээн” ХХК-тай 591,506,878 (таван зуун ерэн нэгэн сая таван зуун зургаан мянга найман зуун далан найм) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Хулдын бүлээн” ХХК-ийн гүйцэтгэх захирал (П.Нямдорж)-д даалгасугай.


3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгүүлж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Сэлэнгэ сумын Засаг дарга (А.Ганбагана), Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга) нарт тус тус даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА


Д.ПҮРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010661

Аймгийн Засаг даргын 2025 оны
07 дугаар сарын 07-ны/ний өдрийн
А/Н87 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулснаас хойш хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн
2	Баталгаат хугацаа	36 сар	Ү.Бямбасүрэн
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана	Э.Эрдэнэжаргал Ү.Бямбасүрэн
4	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Э.Эрдэнэжаргал
5	Захиалагчийн техник хяналтын зардал	10,271,000 төгрөг	Ү.Бямбасүрэн
6	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	5,135,500 төгрөг	Ү.Бямбасүрэн
7	Магадалшгүй ажил	10,271,000 төгрөг	Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувь	Э.Эрдэнэжаргал